

## **ЦАЦРАГИЙН ҮҮСГҮҮРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ДҮРЭМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

#### **1.1. Зорилго**

Энэхүү дүрмийн зорилго нь цацрагийн үүсгүүрийг зөвшөөрөлгүй этгээд ашиглах, зөвшөөрөлгүй шилжүүлэх, хулгайлах, үрэгдүүлэх, гэмтээх болон олж авснаас хүрээлэн буй орчин, нийгэм болон хувь хүнд учирч болох цацрагийн осол аюулаас урьдчилан сэргийлэх, цацраг идэвхт үүсгүүрийн аюулгүй байдлыг хангуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### **1.2. Хамрах хүрээ**

1.2.1. Энэхүү дүрмийн шаардлагуудыг Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасан үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжүүд мөрдөнө.

1.2.2. Цацраг идэвхт изотоп, цацраг идэвхт бодис бүхий төрөл бүрийн зориулалтын багаж төхөөрөмж, цацрагийн үүсгүүрүүдэд энэхүү дүрмийн шаардлагууд хамаарна.

1.2.3. Ашиглагдахгүй болсон цацрагийн үүсгүүрүүд нь мөн энэхүү дүрмийн шаардлагыг хангасан байх ёстой.

### **Хоёр. Захиргааны шаардлагууд**

#### **2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг**

Энэхүү дүрэмд хамаарах цацрагийн үүсгүүртэй холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэгтэй.

2.1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөлд хамаарах үйл ажиллагаа, холбогдох цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах талаар энэхүү дүрмийн холбогдох шаардлагад нийцсэн захиргааны болон техникийн арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх;

2.1.2. Цацрагийн үүсгүүр эсвэл төхөөрөмжийн аюулгүй байдалтай холбоотой ажилд зөвхөн зохих сургалтад хамрагдсан, мэргэшсэн хүнийг томилох;

2.1.3. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдалд нөлөөлж болох нэмэлт өөрчлөлт оруулах бол саналаа цацрагийн хяналтын байгууллагад тухай бүр мэдэгдэх ба зөвшөөрсөн тохиолдолд тэдгээр өөрчлөлтийг хийнэ.

#### **2.2 Цацрагийн аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдлын соёл**

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заагдсан үйл ажиллагааны цар хүрээ, онцлогт тохирсон удирдлагын тогтолцоог бий болгох үүрэгтэй. Үүнд:

2.2.1. цацрагийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тооцсон бодлого, үйл ажиллагаа явуулах;

2.2.2. цацрагийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлж болох асуудлуудыг шуурхай тогтоож, түүнийг зөв оновчтой аргаар шийдвэрлэх;

2.2.3. цацрагийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд хамаарах хүн бүрийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож, тэдгээрийг сургаж мэргэшүүлсэн байх;

2.2.4. цацрагийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын чиглэлээр шийдвэр гаргах эрхийг нарийвчлан тодорхойлсон байх;

2.2.5. Байгууллагын цацрагийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын талаар мэдээлэл солилцох зохион байгуулалтын болон харилцаа холбооны тогтолцоог бий болгох.

### **2.3. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдалд тавигдах шаардлага**

2.3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн холбогдох цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

2.3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн үүсгүүр болон үүсгүүр бүхий хэсэг, байгууламжийг байршуулах, зохион бүтээх, угсрах, ашиглалтад оруулах, ажиллуулах, засварлах, ашиглалтаас гаргахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- батлагдсан дүрэм журам, стандарт, техник, шинжлэх ухааны хөгжлийн хандлагад нийцсэн байх;
- найдвартай удирдлага, зохион байгуулалтаар хангагдсан байх;
- үүсгүүрийг үйлдвэрийн хийцийн дагуу угсрах, ажиллуулахад шаардагдах зай талбайгаар хангасан байх.

### **2.4. Нууцлал болон мэдээллийн аюулгүй байдал**

2.4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заагдсан үйл ажиллагааны хэмжээ, онцлогт тохирсон мэдээллийн удирдлагын тогтолцоог дараах зорилгоор хангасан байх шаардлагатай. Үүнд:

- бусад байгууллагаас нууц гэж хүлээн авсан мэдээллийн нууцлалыг хамгаалсан байх;
- бусад байгууллагаас хүлээн авсан аюулгүй байдалд хамаарах мэдээллийг зөвхөн түүний зөвшөөрөлтэйгөөр гуравдагч талд өгөх;
- аюулгүйн арга хэмжээнд хамаарах мэдээллийн нууцлалыг зөвшөөрөлгүйгээр задруулахгүй байх.

2.4.2. Цацрагийн үүсгүүрийн тодорхой байршил, цацрагийн аюулгүй байдлын нарийвчилсан арга хэмжээ, цацрагийн үүсгүүрийн менежментийн доголдолтой байдлыг тусгасан мэдээлэл, баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий хүмүүс хяналттайгаар ашиглана. Үүнд дараах мэдээлэл хамаарна.

- үүсгүүрийн тодорхой байршил;
- төхөөрөмжийн аюулгүй байдлын төлөвлөгөө, үүсгүүртэй холбоотой аюулгүй байдлын систем;
- цацрагийн аюулгүй байдлын системийн түр зуурын болон байнгын доголдол;
- цацрагийн үүсгүүрийг ашиглах төлөвлөгөө болон бүртгэлүүд;

- цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх, дамжуулахаар төлөвлөсөн огноо, хугацаа;
- ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө ба тогтолцоо эдгээр болно.

## **2.5. Хүний хүчин зүйл**

2.5.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн аюулгүй байдалд нөлөөлж болох бүх ажилтан, албан хаагчдыг сургалтад хамруулах, мэргэшүүлэх үүрэгтэй бөгөөд ажилтнууд нь өөрсдийн аюулгүй байдлын үүрэг хариуцлагыг ухамсарласан, тогтоосон журмын дагуу чиг үүргээ хэрэгжүүлж чаддаг байх үүрэгтэй.

2.5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь биет хамгаалалтын арга хэмжээний талаар бүх ажилтандаа жилд нэгээс доошгүй удаа мэдээлэх, тэдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх сургалт зохиох үүрэгтэй.

2.5.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч сургалтын хөтөлбөрийг тогтмол хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчилж байх үүрэгтэй.

2.5.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн осолд хүргэх хүний хүчин зүйл, алдааны нөлөөллийг багасгахын тулд ханган нийлүүлэгчтэй хамтран ажиллана.

2.5.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах зорилгыг хангахын тулд шаардлагатай багаж хэрэгсэл, аюулгүй байдлын тогтолцоо, зааврыг бий болгосон байх үүрэгтэй. Үүнд:

- Осолд хүргэж болох хүний алдааг аль болох багасгах;
- Хүний алдааг илрүүлэх, тэдгээрийг засах, хор уршгийг арилгах;
- Осол гарсан тохиолдолд шуурхай ажиллагааг хэрэгжүүлэх.

## **2.6. Чанарын хяналт**

2.6.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн хяналтын байгууллагаас тодорхойлсон дүрэм, журам, зааврын шаардлага хангасан чанарын хяналтын хөтөлбөрийг бий болгох үүрэгтэй: Үүнд:

- Цацрагийн аюулгүй байдалд хамаарах тусгай шаардлагууд хангагдсан эсэхийг хянадаг дотоодын хяналтыг бий болгох;
- Цацрагийн аюулгүй байдлын тогтолцоо нь чанартай, чиг үүрэгтээ нийцсэн байх;
- Цацрагийн аюулгүй байдлын арга хэмжээний үр дүнг хянан шалгах, үнэлэх чанарын хяналтын тогтолцоог бий болгох.

2.6.2. Аюулгүй байдлын А, В бүлгийн үүсгүүр бүхий байгууллагын чанарын хяналтын тогтолцоонд ослын болон онцгой байдлын үед авах арга хэмжээний дасгал, сургууль, түүний үнэлгээ, аюулгүй байдлын төлөвлөгөөнд жил бүр тусгасан байвал зохино. Шаардлагатай тохиолдолд дээрх төлөвлөгөөнд тодотгол хийнэ.

## **2.7. Дадлага сургуулилт**

2.7.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү дүрэм болон тусгай зөвшөөрлийн нөхцөлийн шаардлагыг хангаж байгаа эсэх, байгууллагын цацрагийн аюулгүй байдлын тогтолцоог тодорхой хугацаанд сургуулилт явуулж шалгах үүрэгтэй. Энэхүү дадлага сургуулалтад албан хаагчид өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх, арга техник, ойлголт, ур чадварыг сорих, дадлага эзэмших дасгалуудыг багтаасан байвал зохино.

## Гурав. Техникийн шаардлагууд

### 3.1. Цацрагийн үүсгүүрийн ангилал

3.1.1. Тухайлсан нэг цацрагийн үүсгүүрийн хувьд ангилал ба аюулгүй байдлын бүлгийг тухайн үүсгүүрийн хамаарах үйл ажиллагааг нь үндэслэн тогтоож болно. (Хүснэгт 1)

3.1.2. Харин олон үүсгүүрүүдийн хувьд тэдгээрийн идэвх А-ын нийлбэрийг тухайн цацраг идэвхт цөмийн тусгай идэвх буюу аюулын утга (Д утга)-д хувааж ангилал болон аюулгүй байдлын бүлгийг тогтооно. Тооцоолон олсон А/Д утгын нийлбэрийг хүснэгтэд буй А/Д утгатай харьцуулах замаар аюулгүй байдлын бүлгийг тогтооно. (Цацраг идэвхт цөмийн тусгай идэвх буюу аюулын утга (Д утга)-ыг хавсралт 1-т зааснаар авна)

3.1.3. 1 дүгээр хүснэгтэд заасан үйл ажиллагаанд тусгагдаагүй үүсгүүрийн хувьд тэдгээрийн идэвх А-г харгалзах утга Д -д харьцуулж, аюулгүй байдлын бүлгийг тогтооно. Тооцоолон олсон А/Д утгыг хүснэгтэд буй А/Д утгатай харьцуулах замаар аюулгүй байдлын бүлгийг тогтооно.

Хүснэгт 1. Цацрагийн үүсгүүрийн ангилал ба аюулгүй байдлын бүлэг

Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын бүлэг	Үүсгүүрийн ангилал	А/Д утга	Үйл ажиллагаа
A	1	$A/D \geq 1000$	Цацраг идэвхт изотоп бүхий термо-электрик генератор Шарах төхөөрөмж Туяа эмчилгээний зайн шарлагын төхөөрөмж Эмчилгээний гамма хутга
B	2	$1000 > A/D > 10$	Үйлдвэрийн радиографи Өндөр болон дунд тунгийн дотуур шарлагын төхөөрөмж
C	3	$10 > A/D > 1$	Үйлдвэрийн суурин цөмийн хэмжүүр түвшин хэмжих, туузан дамжуургын болон дрежерын гэх мэт
D	4	$1 > A/D > 0.01$	Бага тунгийн дотуур шарлагын төхөөрөмж /Нүдний товгор, байнгын суулгацаас бусад/ Үйлдвэрийн зориулалтын цөмийн хэмжүүр /өндөр идэвхтэй үүсгүүр хамаарахгүй Ясны денситометр Цахилгаан цэнэг саармагжуулагч
	5	$0.01 > A/D$ ба $A >$ чөлөөлөгдөх утга	Бага тунгийн дотуур шарлагын төхөөрөмж, нүдний товгор, байнгын суулгацын үүсгүүр Электрон залгих төхөөрөмж Мессбауэрын спектрометрийн үүсгүүр Позитрон цацаргах томографийн тохируулгын үүсгүүр

Д утга: тухайн цацраг идэвхт цөмийн тусгай идэвх буюу аюулын утга

*А утга: үүсгүүрийн идэвх*

### **3.2. Цацрагийн аюулгүй байдлын үнэлгээ**

3.2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь чанарын хяналтын шаардлагад нийцүүлэн, цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын бүлэг А болон В-д хамаарах үүсгүүрүүдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд холбогдох аюулгүйн үнэлгээг хийлгэх үүрэгтэй ба энэ нь дараах зорилгыг хангасан байх ёстой. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгайлан хамаарах аюул заналыг тодорхойлох буюу өмнө нь тогтоож байсан аюул заналыг тодотгох нэмэлт өөрчлөлт оруулах;
- Цацрагийн аюулгүй байдлын эрсдэл, эмзэг байдлыг үнэлэх;
- Цацрагийн аюулгүй байдлын арга хэмжээний хангамж нөхцөл, чанарыг үнэлэх.

### **3.3. Цацрагийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ**

3.3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн үүсгүүрт хамаарагдаж буй аюулгүй байдлын бүлэг бүрийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанд хамаарагдаж буй цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын бүлэгт тавигдах дүрмийн шаардлагуудыг мөрдөх;
- Үндэсний хэмжээний аюул занал болон тухайн үүсгүүрийн эрсдэл, эмзэг байдлын шинжилгээнд үндэслэсэн аюулгүй байдлыг хангах бусад арга хэмжээг хэрэгжүүлэх.

3.3.2. Цацрагийн аюулгүй байдлын бүлгүүдийн зорилт нь захиргааны болон техникийн холбогдох шаардлагуудыг хослон хэрэглэхэд зохицсон байх ёстой. Цацрагийн аюулгүй байдлыг хангах эдгээр арга хэмжээнүүд нь үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын үзэл баримтлал, цацрагийн үүсгүүрийг зөвшөөрөлгүй хөдөлгөх, олж авахаас хамгаалах, шаардлагатай түвшинд хүргэх цацрагийн хамгаалалтын нэгдсэн арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг байна.

3.3.3. Хавсралт 2, хавсралт 3-т заасны дагуу цацрагийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.

## **Дөрөв. Цацрагийн үүсгүүрийг олж авах, эзэмших, хуваарилахад тавигдах шаардлага**

### **4.1. Цацрагийн үүсгүүрийг нийлүүлэх болон хуваарилах**

4.1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн үүсгүүрийг нийлүүлэх, хуваарилахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Нийлүүлэгч эсвэл хүлээн авагч нь цацрагийн үүсгүүрийг хүлээн авахдаа цацрагийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл авсан байх;
- Авч буй цацраг идэвхт изотоп, цацрагийн төрөл нь хүлээн авагчийн бизнесийн болон эзэмших хязгаар, тусгай зөвшөөрөлд заагдсан нөхцөлд нийцсэн байх.

4.1.2. Битүү үүсгүүрийг худалдаж авахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийлүүлэгч эсвэл үйлдвэрлэгчтэй 2 талт гэрээ байгуулах ба тус гэрээнд

ашиглалтын хугацаа дууссны дараа үүсгүүрийг үйлдвэрлэгч болон нийлүүлэгчид буцаах асуудлыг тусгах шаардлагатай.

4.1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь битүү үүсгүүрийг импортлохдоо идэвх нь 100МБк-ээс их идэвхтэй цацрагийн үүсгүүрийг хүлээн авсан баримттай нь үйлдвэрлэгчид буцаах гэрээ байгуулах, эсвэл хаягдлын менежментийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх асуудлаа тодорхойлсон байх шаардлагатай.

## **4.2. Цацрагийн үүсгүүрийг экспортлох**

4.2.1. Цацраг идэвхт үүсгүүрийг экспортлохоор төлөвлөж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үүсгүүрийг экспортод гаргахаас өмнө цацрагийн хяналтын байгууллагаас тусгай зөвшөөрөл авна.

4.2.2. 1, 2 дугаар ангиллын цацрагийн үүсгүүрийг экспортлоход дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- цацрагийн үүсгүүрийг хүлээн авагч байгууллага нь холбогдох зөвшөөрөлтэйг нотолсон импортлогч улсаас ирүүлсэн албан бичиг;
- импортлогч улсын эрх бүхий байгууллагаас цацрагийн үүсгүүрийг хүлээн авагчид олгосон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн хуулбар;
- Ашиглахгүй тохиолдолд цацрагийн үүсгүүрийг буцаан импортлохыг тохиролцсон бол талуудын хооронд байгуулсан гэрээний хуулбар;

4.2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 1, 2 дугаар ангиллын цацрагийн үүсгүүрийг экспортлохдоо импортлогч талын хяналтын байгууллагад үүсгүүрийг илгээхээс 7-оос доошгүй хоногийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ.

## **4.3. Цацрагийн үүсгүүрийг импортлох**

4.3.1 1, 2 дугаар ангиллын цацраг идэвхт үүсгүүрийг импортлохоор төлөвлөж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үүсгүүрийг импортлохын өмнө цацрагийн хяналтын байгууллагаас тусгай зөвшөөрөл авна.

4.3.2 Цацрагийн үүсгүүрийг импортлох зөвшөөрөл хүссэн өргөдөлд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- Экспортлогчийн нэр, эрх бүхий хяналтын байгууллагаас олгосон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн хуулбар;
- Экспортлогчийн хаяг, байршил эсвэл бизнесийн үйл ажиллагааны төв;
- Ашиглаж буй үүсгүүрийн изотопын нэр, идэвх;
- Тухайн бүс нутгийн нийлүүлэгчийн нэр, эрх бүхий хяналтын байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар;
- Ашиглахгүй болсон тохиолдолд цацрагийн үүсгүүрийг буцаан экспортлохыг тохиролцсон бол талуудын хооронд байгуулсан гэрээний хуулбар эдгээр болно.

## **4.4 . Цацрагийн үүсгүүрийг шилжүүлэх**

4.4.1. Цацрагийн хяналтын байгууллагаас олгосон хүчин төгөлдөр зөвшөөрөлгүйгээр цацрагийн үүсгүүрийг шилжүүлэхийг хориглоно.

4.4.2. Цацрагийн үүсгүүрийг тээвэрлэхдээ “Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх дүрэм”-ийг мөрдөнө.

### **Тав. Цацрагийн аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлагууд**

#### **5.1. Цацрагийн аюулгүй байдлын бүлэг, түүний зорилго**

5.1.1. Цацрагийн аюулгүй байдлыг хангахад шаардагдах арга хэмжээнд нь үндэслэн цацраг идэвхт үүсгүүрийг аюулгүй байдлын 4 бүлэгт хуваана.

5.1.2. Бүлэг бүрд дараах аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “D” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүрийн хувьд аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тогтоохдоо:

- Үүсгүүрийн ашиглалтын аюулгүй ажиллагааг хангах;
- Шаардлага хангахуйц байдлаар хамгаалах;
- Үүсгүүр байгаа эсэхийг жил бүр шалгах.

2. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “C” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүрийн хувьд аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тогтоохдоо:

- зөвшөөрөлгүй нэвтрэх боломжийг хаах;
- үүсгүүр байгаа эсэхийг хагас жил бүр шалгах.

3. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “B” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүрийн хувьд аюулгүй байдлын арга хэмжээг тогтоохдоо:

- зөвшөөрөлгүй нэвтрэх боломжийг хаах;
- зөвшөөрөлгүй нэвтрэх тохиолдлыг илрүүлэх болон үүсгүүрийг цаг тухайд нь олж авах;
- үүсгүүр байгаа эсэхийг долоо хоног бүр шалгах.

4. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “A” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүрийн хувьд аюулгүй байдлын арга хэмжээг тогтоохдоо:

- зөвшөөрөлгүй нэвтрэх боломжийг хаах;
- зөвшөөрөлгүй нэвтрэх тохиолдлыг илрүүлэх болон үүсгүүрийг цаг тухайд нь олж авах;
- үүсгүүрийг аюулгүй болгох боломжтой хариу арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх;
- үүсгүүр байгаа эсэхийг өдөр бүр шалгах.

#### **5.2. Цацрагийн аюулгүй байдлын төлөвлөгөөнд тавигдах шаардлага**

5.2.1. Дараах тохиолдолд аюулгүй байдлын тусгай төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай. Үүнд:

- Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “A” болон “B” бүлэгт хамаарах цацраг идэвхт үүсгүүр, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжтэй харьцах;
- Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бол.

5.2.2. Цацрагийн аюулгүй байдлын төлөвлөгөө нь наад зах нь хавсралт 4 -д заасан мэдээллийг агуулсан байх;

5.2.3. Цацрагийн аюулгүй байдлын төлөвлөгөөг жил бүр шалгаж, зохих тодотгол, үнэлгээ хийж байх;

5.2.4. Цацрагийн аюулгүй байдлын тогтолцоо, төлөвлөгөөнд бэрхшээл учирсан үед энэхүү дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу нэн даруй мэдээлэх.

### **5.3. Зөөврийн цацраг идэвхт үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ**

5.3.1. Хээрийн болон бусад зөөврийн хэрэглээний үед цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангах боломжгүй бол аюулгүй байдлын түвшинг бууруулахгүйгээр бололцоотой хамгаалалтын арга хэмжээг авна;

5.3.2. Дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ 15-аас доошгүй хоногийн өмнө цацрагийн хяналтын байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авсан байх;

5.3.3. Боломжит арга хэмжээ нь зөвхөн зөвшөөрөгдсөн хугацаанд хэрэгжих бөгөөд энэхүү хугацаа дууссаны дараа тусгай зөвшөөрөлд заасан аюулгүй байдлын арга хэмжээг сэргээнэ.

### **5.4. Шалган нэвтрүүлэхэд тавигдах шаардлага**

5.4.1. Цацрагийн үүсгүүрт тавигдах шалган нэвтрүүлэх шаардлага нь тухайн үүсгүүрийн аюулгүй байдлын бүлэгт тохирсон байна.

5.4.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цацраг идэвхт материал болон цөмийн материал агуулсан тоног төхөөрөмжид нэвтрэх хүмүүсийг байнга хянан шалгаж байх шаардлагатай бөгөөд зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигчээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авсан этгээд нэвтрэх эрхтэй.

5.4.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь харгалзагчгүйгээр цацраг идэвхт материал болон цацрагийн үүсгүүр бүхий төхөөрөмжид нэвтрэх этгээдийн жагсаалтыг батлах үүрэгтэй бөгөөд энэхүү баталгаажсан жагсаалтад буй этгээдийн найдвартай байдлыг шалгасан байвал зохино.

5.4.4. Үүсгүүрийн байршил руу нэвтэрч буй бүх этгээд нь зохих ёсны дагуу бүртгэгдсэн үнэмлэхтэй байна.

5.4.5. Нэвтрэх эрх бүхий бүх ажиллагчдыг тодорхой хугацаанд шалгаж байна.

### **5.5. Түлхүүрийн хяналтад тавигдах шаардлага**

5.5.1. Түлхүүрийн хяналт нь байгууламж, эсхүл үйл ажиллагаа, цацраг идэвхт үүсгүүрийн аюулгүй байдлын бүлэгт тохирсон байна.

5.5.2. Цацраг идэвхт үүсгүүрийн менежменттэй холбогдох түлхүүр эзэмшигч, хадгалагч, үүсгүүрийн байршил руу нэвтэрсэн бүх этгээдийг тусгайлан бүртгэх ба бүртгэлийг хадгална.

### **5.6. Осол, гамшгийн үед цацрагийн аюулгүй байдлын хангах**

5.6.1. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын А болон В бүлгийн байгууламж, цацраг идэвхт үүсгүүртэй холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон бэлэн байдлын төлөвлөгөөтэй байна.

5.6.2. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын С бүлгийн цацраг идэвхт үүсгүүр бүхий байгууллага нь осол, гамшгийн үед цацрагийн аюулгүй байдлыг хангах тусгай төлөвлөгөөтэй байх шаардлагагүй боловч байгууллагын гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөнд энэ асуудал тусгагдсан байвал зохино.

5.6.3. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь цацраг идэвхт үүсгүүрийн тоо, төрөл, идэвхтэй уялдсан байна. Осол, гамшгийн үед цацрагийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөнд дараах асуудлуудыг тусгана. Үүнд:

- Үүсгүүр алдагдсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагуудад нэн даруй мэдэгдэх;



- Алдагдсан болон хулгайлагдсан үүсгүүрийг олох анхан шатны арга хэмжээг шуурхай авах;
- Өмнө нь тоологдоогүй үүсгүүр, олдсон эзэнгүй үүсгүүр, эсвэл алдсан, хулгайлагдаад эргэж олсон үүсгүүрийг аюулгүй болгох арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх;
- Их хэмжээний аюул занал буюу онцгой аюулын байдалд энэ дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7-ын дагуу хариу арга хэмжээ авах;
- хэвлэлд мэдээлэх.

5.6.4. Осол, гамшгийн үед ажиллах журам болон горимын гүйцэтгэлийг хянаж, жилд 1-ээс доошгүй удаа шинэчилж байна.

### **5.7. Их хэмжээний аюул занал буюу онцгой аюулын үед цацрагийн аюулгүй байдлыг хангах**

5.7.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч бүр өөрийн байгууламж, эсвэл үйл ажиллагаа, цацрагийн үүсгүүртэй холбоотой аюул занал гарсан үед хариу арга хэмжээ авах төлөвлөлттэй холбоотой асуудлаар холбогдох төрийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.

5.7.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч бүр гарч болзошгүй аюулын үед авах холбогдох хариу арга хэмжээ, аюулгүйн холбоо болон тагнуулын мэдээллийг хууль тогтоомжийн хүрээнд урьдчилан журмаар зохицуулна.

5.7.3. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын А болон В бүлэгт хамаарах цацраг идэвхт үүсгүүртэй холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үүсгүүр эсвэл үүсгүүр хадгалж буй байршилд онцгой аюулын сэжиг илэрсэн тохиолдолд гарч болзошгүй аюултай уялдуулан дараах аюулгүйн арга хэмжээг авна. Үүнд:

- Хэрэв үүсгүүртэй холбоотой байгаа тохиолдолд нэн даруй үүсгүүрийг аюулгүй хадгалах байранд байршуулна;
- Нэмэлт хяналтын камер, эсхүл нэмэлт дохиолол бүхий 24 цагийн хамгаалалтаар хангана.

5.7.4. Онцгой аюул занал цаашид байхгүй гэж тодорхойлогдох хүртэл аюулгүйн арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн авна.

### **Зургаа. Ашиглагдахгүй цацрагийн үүсгүүрийн менежмент**

#### **6.1. Ашиглагдахгүй цацрагийн үүсгүүрийг хадгалах болон боловсруулах**

6.1.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь битүү цацраг идэвхт үүсгүүр буюу төхөөрөмжийг задалж салгахыг хориглоно.

6.1.2. Цацрагийн үүсгүүрийг хаягдал болгон удаан хугацаанд хадгалах, боловсруулах ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууламж нь хяналтын байгууллагын зөвшөөрсний дагуу удаан хугацааны хадгалах болон боловсруулалт хийх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.1.3. Цацрагийн үүсгүүрийг удаан хугацаагаар хадгалах тусгай зөвшөөрөл бүхий байгууламж нь аюулгүй байдлын хамгийн өндөр эрсдэл бүхий бүлэгт хамаарах бөгөөд тэдгээрт тавигдах шаардлагыг хангасан байх ёстой.

#### **6.2. Ашиглагдахгүй болсон цацрагийн үүсгүүрт шуурхай арга хэмжээ авах**

6.2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй цацрагийн үүсгүүрийн тооллогыг жил бүр хийх үүрэгтэй бөгөөд байнга ашиглагдахгүй байгаа цацрагийн үүсгүүрүүдийг тогтоож байх ёстой.

6.2.2. Тусгай зөвшөөрөлд тусгайлан заагдаагүй бол ашиглагдахгүй болсон цацрагийн үүсгүүрийн талаар шуурхай арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай.

6.2.3. Шуурхай арга хэмжээнд дараах үйл ажиллагааг хамааруулж болно. Үүнд:

- Цаашид үүсгүүрийг ашиглаж болох өөр тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэх;
- Цацрагийн үүсгүүрийг үйлдвэрлэгч буюу ханган нийлүүлэгчид буцаах;
- Цацрагийн үүсгүүрийг хадгалах зөвшөөрөл бүхий байгууллагад түр буюу удаан хугацаагаар шилжүүлэх.

6.2.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглахгүй байгаа цацрагийн үүсгүүрийг цацрагийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл авч, үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор удаан хугацаагаар хадгалах байгууламжид шилжүүлнэ.

## **Долоо. Бүртгэх, мэдээлэх шаардлага**

### **7.1. Үүсгүүрийн бүртгэл тооллого**

7.1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн ашиглаж буй үүсгүүрүүдийг бүртгэлтэй тохирч байгаа эсэхийг шалгаж байх үүрэгтэй.

7.1.2. Цацрагийн үүсгүүр бүрийг аюулгүй байдлын бүлгээс нь хамааруулан тодорхой давтамжтайгаар жилийн тооллогод хамруулна.

7.1.3. Бүртгэл тооллогын материалыг тухайн цацрагийн үүсгүүрийн хамаарч буй аюулгүйн бүлэгт тавигдах шаардлагын дагуу цацрагийн аюулгүй байдлын зохих түвшинд хамгаалах үүрэгтэй.

7.1.4. Бүртгэлийг дараах тохиолдолд шинэчилж, тодотгол хийж байвал зохино. Үүнд:

1. Жил тутмын тооллогын үед
2. Үзүүлэлтүүд нь өөрчлөгдсөн үед
3. Цацрагийн үүсгүүрийг шилжүүлсэн үед

7.1.5. Цацрагийн үүсгүүр бүрд хамаарах бүртгэлд дараах зүйлсийг тусгавал зохино. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүрийн байршил
2. Изотопын нэр
3. Идэвхийг хэмжсэн он сар өдөр буюу анхны идэвх
4. Хувийн дугаар
5. Физик, химийн төлөв байдал
6. Цацрагийн үүсгүүрийн ашиглалтын талаарх мэдээлэл (хадгалах байрнаас гаргасан болон оруулсан шилжилт хөдөлгөөн гэх мэт)
7. Хүлээн авсан, шилжүүлсэн үүсгүүрүүд

### **7.2. Мэдээлэх шаардлагууд**

7.2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль тогтоомжид заасны дагуу дараах тайлан мэдээг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлж байх үүрэгтэй. Үүнд

1. Энэхүү дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1-т заасан цацрагийн үүсгүүрийн анхны жагсаалтууд болон тэдгээрт орсон өөрчлөлт хөдөлгөөнүүд;

2. Ослын болон хэвийн бус дараах тохиолдлуудыг заавал мэдээлнэ. Үүнд:

- Цацрагийн үүсгүүр хяналтаас гарсан аливаа тохиолдол;
- Цацрагийн үүсгүүрт зөвшөөрөлгүй халдсан эсвэл үүсгүүрийг зөвшөөрөлгүй ашигласан;
- Цацраг идэвхт үүсгүүр бүхий багаж төхөөрөмжийн эвдрэл гэмтэл (аюулгүй байдалд нөлөөлөхүйц);
- Бүртгэл тооллогод хамруулаагүй аливаа цацрагийн үүсгүүрийг илрүүлбэл;
- Халдлага болон бусад хэвийн бус аливаа үйл ажиллагаа.

3. Цацрагийн аюулгүй байдлын систем нь эрсдэлтэй болох нь тогтоогдсон бол тэдгээрийг засаж, авсан арга хэмжээнүүд;

4. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлж болох үйл ажиллагааны аливаа өөрчлөлт эсвэл өөрчлөх төлөвлөгөө;

5. Импортлохоор төлөвлөж байгаа цацрагийн үүсгүүрийг буцаахтай холбоотой аливаа баримт бичиг гэрээний хуулбар.

7.2.2. Энэхүү дүрмийг зөрчсөн аливаа тохиолдлыг, мөн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасан мэдээллийн хамт 24 цагийн дотор цацрагийн хяналтын байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

7.2.3. Аюулгүй байдлын А, В бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүрийн хувьд дараах тохиолдолд 1 цагийн дотор яаралтай мэдээлнэ. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүр алдагдах;
2. Цацрагийн үүсгүүрийг хулгайлахыг оролдох болон бусад хорлонтой үйл ажиллагаа;
3. Цацрагийн үүсгүүрт халдах болон бусад хэвийн бус оролдлого.

7.2.4. Хууль, дүрэмд өөрөөр заагаагүй бол дээр дурдсан бүх мэдээллүүдийг 30 хоногийн дотор бичгээр үйлдэж хүргүүлэх үүрэгтэй.

7.2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдалтай холбоотой аливаа хэвийн бус үйлдлийг цацрагийн хяналтын байгууллага болон хяналтын байгууллагаас тодорхойлсон холбогдох бусад байгууллагуудад мэдээлэх үүрэгтэй.

### **7.3. Зөрчил болон ослын тохиолдол**

7.3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү дүрмийн шаардлагуудыг зөрчсөн тохиолдол илэрвэл дараах шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой. Үүнд:

1. Зөрчлийг шалгах, түүний шалтгаан үр дагаврыг тогтоох;
2. Зөрчлийг арилгах арга хэмжээ авах, ижил төрлийн зөрчил давтагдахаас сэргийлэх;
3. Цацрагийн хяналтын байгууллагад 24 цагийн дотор мэдээлэх. (Зөрчлийн шалтгаан, болсон явдал, хор уршиг, зөрчлийг арилгасан болон урьдчилан сэргийлсэн талаар);
4. Энэхүү дүрэмд заасан холбогдох бусад арга хэмжээг авах.

7.3.2. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын А, В бүлгийн үүсгүүр хяналтаас гарсан тохиолдолд (алдагдах, хулгайлагдах эсвэл аюулгүй байдлын

зөрчил) 1 цагийн дотор болсон явдлыг Тагнуулын болон цацрагийн хяналтын байгууллагад яаралтай мэдэгдэнэ.

7.3.3. Цацрагийн хяналтын байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийн дагуу урьдчилан сэргийлэх болон үүссэн нөхцөл байдал зөрчлийг арилгах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлнэ.

#### **7.4. Санал хүсэлт**

7.4.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн үүсгүүрийн ашиглалтын байдалд нөлөөлж болох хэвийн бус тохиолдлуудын талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудад хандаж хүсэлт, заавар, зөвлөмж авч болно.

xxxXXXxxx

### ЗАРИМ ЦАЦРАГ ИДЭВХТ ИЗОТОПЫН “Д” УТГА

Цацраг идэвхт изотоп	1000×Д		10×Д		Д		0.01×Д	
	ТБк	Ки*	ТБк	Ки*	ТБк	Ки*	ТБк	Ки*
Am-241	60	2000	0.6	20	0.06	2	$6 \times 10^{-4}$	0.02
Am-241/Be	60	2000	0.6	20	0.06	2	$6 \times 10^{-4}$	0.02
Au-198	200	5000	2	50	0.2	5	0.002	0.05
Cd-109	$2 \times 10^4$	$5 \times 10^5$	200	5000	20	500	0.2	5
Cf-252	20	500	0.2	5	0.02	0.5	$2 \times 10^{-4}$	0.005
Cm-244	50	1000	0.5	10	0.05	1	$5 \times 10^{-4}$	0.01
Co-57	700	$2 \times 10^4$	7	200	0.7	20	0.007	0.2
Co-60	30	800	0.3	8	0.03	0.8	$3 \times 10^{-4}$	0.008
Cs-137	100	3000	1	30	0.1	3	0.001	0.03
Fe-55	$8 \times 10^5$	$2 \times 10^7$	8000	$2 \times 10^5$	800	$2 \times 10^4$	8	200
Gd-153	1000	$3 \times 10^4$	10	300	1	30	0.01	0.3
Ge-68	70	2000	0.7	20	0.07	2	0.007	0.02
H-3	$2 \times 10^6$	$5 \times 10^7$	$2 \times 10^4$	$5 \times 10^5$	2000	$5 \times 10^4$	20	500
I-125	200	5000	2	50	0.2	5	0.002	0.05
I-131	200	5000	2	50	0.2	5	0.002	0.05
Ir-192	80	2000	0.8	20	0.08	2	$8 \times 10^{-4}$	0.02
Kr-85	$3 \times 10^4$	$8 \times 10^5$	300	8000	30	800	0.3	8
Mo-99	300	8000	3	80	0.3	8	0.003	0.08
Ni-63	$6 \times 10^4$	$2 \times 10^6$	600	$2 \times 10^4$	60	2000	0.6	20
P-32	$1 \times 10^4$	$3 \times 10^5$	100	3000	10	300	0.1	3
Pd-103	$9 \times 10^4$	$2 \times 10^6$	900	$2 \times 10^4$	90	2000	0.9	20
Pm-147	$4 \times 10^4$	$1 \times 10^6$	400	$1 \times 10^4$	40	1000	0.4	10
Po-210	60	2000	0.6	20	0.06	2	$6 \times 10^{-4}$	0.02
Pu-238	60	2000	0.6	20	0.06	2	$6 \times 10^{-4}$	0.02
Pu-239/Be	60	2000	0.6	20	0.06	2	$6 \times 10^{-4}$	0.02
Ra-226	40	1000	0.4	10	0.04	1	$4 \times 10^{-4}$	0.01
Ru-106(Rh-106)	300	8000	3	80	0.3	8	0.003	0.08
Se-75	200	5000	2	50	0.2	5	0.002	0.05
Sr-90(Y-90)	1000	$3 \times 10^4$	10	300	1	30	0.01	0.3
Tc-99m	700	$2 \times 10^4$	7	200	0.7	20	0.007	0.2
Tl-204	$2 \times 10^4$	$5 \times 10^5$	20	5000	20	500	0.2	5
Tm-170	$2 \times 10^4$	$5 \times 10^5$	200	5000	20	500	0.2	5
Yb-169	300	8000	3	80	0.3	8	0.003	0.08

\*- Тооцоонд ашиглахад хялбар болгохын тулд ТБк –ээс шилжүүлж, ойролцоолсон утга.

xxxXXXxxx

## **ЦАЦРАГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАХИРГААНЫ БОЛОН ТЕХНИКИЙН АРГА ХЭМЖЭЭНҮҮД**

### **Захиргааны арга хэмжээнүүд:**

Цацрагийн үүсгүүрийг аюулгүй ашиглах болон цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хариуцаж буй ажилтнуудын шууд ашиглах арга техник, заавар журам, бодлогыг хэрэгжүүлэх нь захиргааны арга хэмжээнд хамаарна. Захиргааны арга хэмжээ нь техникийн арга хэмжээнд дэмжлэг болох, түүнийг бататгах зорилгоор хэрэглэгдэнэ. Захиргааны арга хэмжээнд дараах зүйлсийг оруулж болно. Үүнд:

1. Шалган нэвтрүүлэх журам;
2. Орох/гарах хэсэгт тавьсан дохиолол /цацраг мэдрэгч бүхий дохиолол г.м/;
3. Түлхүүрийг хяналттай байлгах журам;
4. Дүрс бичлэг, камерын хяналт, ажилтныг ажиглах;
5. Цацрагийн үүсгүүрийн менежментийн холбогдох бүртгэл;
6. Цацрагийн үүсгүүрийн тооллого, бүртгэл;
7. Мөрдөх дүрэм, журам, заавар;
8. Ажиллагчдын найдвартай байдлыг шалгах;
9. Мэдээллийн аюулгүй байдал;
10. Чанарын болон дотоодын хяналт;
11. Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын соёлыг бий болгох гэх мэт.

### **Техникийн арга хэмжээнүүд:**

Цацрагийн үүсгүүр, төхөөрөмжид зөвшөөрөлгүй этгээд нэвтрэх, ашиглахаас сэргийлсэн биет хамгаалалтын арга хэмжээ хамаарна. Үүнд:

1. Хамгаалалтын хашаа;
2. Хана;
3. Тор;
4. Тээвэрлэлтийн сав баглаа;
5. Хаалганы цоож, түгжээ;
6. Түгжээ бүхий хамгаалалтын контейнер;
7. Халдлагаас хамгаалсан цацрагийн үүсгүүрийн бэхэлгээ гэх мэт.

xxxXXXxxx

### **АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТАД БАЙГАА ЦАЦРАГИЙН ҮҮСГҮҮРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД**

1. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “D” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүр болон түүнтэй холбоотой үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүд

Зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “D” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а/ Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагааг зөвхөн зөвшөөрөл бүхий этгээд зохион байгуулж хэрэгжүүлнэ.
- б/ Хамгийн наад зах нь цацрагийн хамгаалалтын дүрэм болон үйлдвэрийн стандартыг хангаж байхаар хамгаалалтыг гүйцэтгэнэ.
- в/ Цацрагийн үүсгүүрийн хамгаалалтыг тэдгээрийн үндсэн үзүүлэлтүүдэд нийцүүлэн гүйцэтгэнэ.
- г/ Цацрагийн үүсгүүрийн бүртгэлийг жил бүр шинэчлэн хийж шалгана.

2. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “C” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүр болон түүнтэй холбоотой үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүд

Зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “C” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а/ Цацрагийн үүсгүүрийг зөвшөөрөлгүй этгээдээс тусгаарлах хамгийн багадаа нэг техникийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- б/ Цацрагийн үүсгүүр байгаа газар бүрт шалган нэвтрүүлэх хяналтыг гүйцэтгэнэ.
- в/ Цацрагийн үүсгүүрийн бүртгэл тооллогыг хагас жил тутам хийнэ.
- г/ Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдалтай холбоотой заалтуудыг ослын бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгасан байна.

3. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “B” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүр болон түүнтэй холбоотой үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүд

Зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “B” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а/ Цацрагийн үүсгүүрийг зөвшөөрөлгүй этгээдээс тусгаарлах хамгийн багадаа хоёр арга хэмжээг хэрэгжүүлнэ, үүнээс хамгийн багадаа нэг нь техникийн арга хэмжээ байна.
- б/ Цацрагийн үүсгүүр байгаа газар бүрт шалган нэвтрүүлэх хяналтыг гүйцэтгэх бөгөөд зөвшөөрөлгүй нэвтрэлтийг

илрүүлсэн хүн тухай бүр түүнийг дохиоллын төв болон холбогдох газарт мэдээлнэ.

- в/ Цацрагийн үүсгүүрийн бүртгэл тооллогыг 7 хоног бүр хийнэ.
- г/ Цацрагийн үүсгүүрт хамаарах ослын бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шалгах дасгал сургуулилт хийх ба сайжруулан шинэчилж байна.
- д/ Дүрмийн 15 дахь заалтын дагуу цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх хувь хүний найдвартай байдлыг хангах зорилгоор түүний үндсэн мэдээллүүдийг шалгана.
- е/ Цацрагийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шалгах дасгал сургуулилт хийж, сайжруулан шинэчилж байна
- ё/ Нууц мэдээллийн аюулгүй байдлыг шалгана.
- ж/ Хорлон сүйтгэх үйл ажиллагаанд ашиглахаас сэргийлэх, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг шаардлагатай үед хэрэгжүүлж, сайжруулна.

4. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “А” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүр болон түүнтэй холбоотой үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүд

Зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын “А” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а/ Цацрагийн үүсгүүрийг зөвшөөрөлгүй этгээдээс тусгаарлах хамгийн багадаа хоёр техникийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- б/ Цацрагийн үүсгүүр байгаа газар бүрт шалган нэвтрүүлэх хяналтыг гүйцэтгэх бөгөөд зөвшөөрөлгүй нэвтрэлт бүрийг дохиоллын системээр илрүүлнэ.
- в/ Шаардлагатай тохирох холбооны хэрэгслээр хангагдсан байх ба хамгаалалтын алба /эсвэл хүчний байгууллага/ нь шуурхай арга хэмжээг хэрэгжүүлэн дохиоллын төв болон холбогдох газарт мэдээлнэ.
- д/ Цацрагийн үүсгүүрийн бүртгэл тооллогыг өдөр бүр хийнэ.
- е/ Цацрагийн үүсгүүрт хамаарах ослын бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шалгах дасгал сургуулилт хийх ба сайжруулан шинэчилж байна.
- ё/ Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хувь хүний найдвартай байдлыг хангах зорилгоор түүний үндсэн мэдээллүүдийг шалгана.
- ж/ Цацрагийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шалгах дасгал сургуулилт хийж, сайжруулан шинэчилж байна.
- з/ Нууц мэдээллийн аюулгүй байдлыг шалгана.
- и/ Хорлон сүйтгэх үйл ажиллагаанд ашиглахаас сэргийлэх, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг шаардлагатай үед хэрэгжүүлэх, сайжруулах, шалгах дасгал сургуулилт хийнэ.



## **ЦАЦРАГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА, ХЭЛБЭР**

Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлын бүлэг “А”, “В” бүлэгт хамаарах цацрагийн үүсгүүрүүд болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулж буй байгууламжид аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө шаардагдана. Эрсдэл бүхий аюулгүй байдлын бүлэглэлд хамаарахгүй хэдий ч цацрагийн хяналтын байгууллагаас цацрагийн үүсгүүр болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулж буй байгууламж нь аюул эрсдэлд байна гэж тодорхойлбол цацрагийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө шаардлагатай юм.

Аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг жил бүр аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу шалгаж, үнэлгээ хийнэ. Шалгалт, үнэлгээний дүнг үндэслэн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг дахин хянаж сайжруулна. Цацрагийн аюулгүй байдлын төлөвлөгөө болон аюулгүй байдлын системд ямар нэгэн учир дутагдал илэрвэл даруй засах ба холбогдох газарт тайлагнана. Цацрагийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө нь цацрагийн үүсгүүрт хамаарах аюулгүй байдлын ухагдахуун, заалтуудыг ойлгох, үнэлэх бүх мэдээллийг агуулсан байна. Төлөвлөгөөнд дараах мэдээллүүдийг оруулна. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүр ба түүний хэрэглээг тайлбарласан байна.
  - Үүсгүүр болон түүний хэрэглээний талаарх мэдээллийг тусгай зөвшөөрөл дээрээс нь авна.
  - Олон тооны үүсгүүр ашиглаж байвал үүсгүүрүүдийг тусгай бүлэглэлээр нь авч үзнэ.
  
2. Цацрагийн үүсгүүр ашиглаж, хадгалж буй барилга байгууламж, хүрээлэн буй орчны талаар тайлбарласан байх ба дараах мэдээллийг тусгана.
  - Сургуулийн барилга, аж үйлдвэр, зөвшөөрөл бүхий байгууламжийн ойролцоох орон сууц, худалдааны төвүүд;
  - Гал, үер, хар шуурга зэрэг байгалийн онц аюултай үзэгдлээс шалтгаалан байгууламжид үүсэж болзошгүй аюулын нөлөөлөл;
  - Улс төрийн жагсаал, цуглаан зэрэг иргэний хөдөлгөөний түүх;
  - Эмх замбараагүй байдал ба гэмт хэргийн гаралт.
  
3. Хүн амд нээлттэй талбайд байрлах барилга байгууламжийн байршлын талаарх мэдээллийг тусгана. Үүнд:
  - Ойролцоо байрлах гудамж, талбай;
  - Ойролцоох цагдаа болон хүчний байгууллага, постууд.
  
4. Цацрагийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө нь дараах зорилтуудыг агуулсан байна. Үүнд:
  - Хулгай, дээрэм эсвэл хорлон сүйтгэх үйл ажиллагаанд ашиглагдах байдал үүсэхээс сэргийлэх, хамгаалах тусгай арга хэмжээ;
  - Таамаглаагүй хор уршгаас сэргийлэхэд шаардагдах хяналт хийх;
  - Багаж төхөөрөмж, эд зүйлсийн аюулгүй байдал хангагдсан байх.

5. Цацрагийн аюулгүй байдлыг хангах техникийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Аюулгүй байдлыг хангах, шинжилгээ хийх, илрүүлэх, бүртгэх, саатуулах, хариу арга хэмжээ авах ба холбоо барих техникийн арга хэмжээ, /торон хашаа, хана, гарц, тээвэрлэлтийн хайрцаг, цоож, замын хаалт, удаашруулагч гэх мэт/;
- Таамаглагдаж буй аюул заналын эсрэг арга хэмжээний чанарыг үнэлэх процедур.

6. Цацрагийн аюулгүй байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авна. Үүнд:

- Дүрэм, журам, зөвлөмж, заавар, чиглэл;
- Аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдлын соёлыг бий болгох;
- Хүмүүс болон бүлэг хүмүүсийн үүрэг, хариуцлага;
- Давтамжтай болон давтамжгүй үйл ажиллагаа ба засвар үйлчилгээ;
- Хувь хүний найдвартай байдлын тодорхойлолт ба нэвтрэх зөвшөөрлийн зохион байгуулалтын арга хэрэгсэл;
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэрэгсэл;
- Ослын бэлэн байдлын төлөвлөгөө;
- Сургалт дадлагажилт.

7. Төлөвлөгөөний үр нөлөөтэй байдлыг давтамжтайгаар үнэлэх ба түүнийг сайжруулах арга хэмжээ авна.

- Бүртгэлийн хяналтын хуваарь;
- Хөндлөнгийн групп төлөвлөгөөг үнэлэх ба дахин хянах хуваарь.

8. Үүсгүүрийн аюулгүй байдлыг тогтвортой байлгах арга хэмжээг авна. Үүнд:

- Ажил гүйцэтгэх түр талбай болон байгууламж руу үүсгүүрийг тээвэрлэх үеийн цацрагийн аюулгүй байдлыг хангах процедур журам;
- Түр талбайд хадгалах процедур журам.

9. Мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, стандартын жагсаалт эдгээр болно.